



МОНГОЛ УЛСЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД

17060 Улаанбаатар хот. Хан-Уул дүүрэг.
Чингисийн өргөн чөлөө Засгийн газрын XIV байр
Утас: 6226-3051, Факс: (976) 7004-3479

2018.10.10 № a/3528


танай _____ -ны № _____ -т

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА
Г.ЗАНДАНШАТАР ТАНАА

Эрчим хүчний яаманд 2018 оны III улиралд иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол, санал, хүсэлт тэдгээрийг шийдвэрлэсэн байдал, зохион байгуулж хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай тайланг хавсралт хүснэгтийн дагуу гаргаж хүргүүлэв.

Хүлээн авч танилцана уу.

Хавсралт: ... хуудастай.



ЦДАВААСҮРЭН

008001053

**ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМАНД 2018 ОНЫ III УЛИРЛЫН
БАЙДЛААР ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ
ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДЛЫН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА**

Тус яам, иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, хариу өгөх ажиллагааг “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай“ Монгол Улсын хууль, бусад хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж байна.

2018 оны III улиралд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, тэдгээрийг шийдвэрлэсэн байдал, зохион байгуулж хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай мэдээ, танилцуулгыг тогтоосон журам, хугацааны дотор гаргаж, Сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулан дүгнэлт, шийдвэр гаргуулж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.

Тус яаманд 2018 оны III улиралд нийт 344 өргөдөл ирснээс хуулийн хугацаанд 325 өргөдлийг шийдвэрлэж, бусад байгууллагад 52 иргэний өргөдлийг шилжүүлж шийдвэрлүүлсэн, 32 иргэний өргөдлийг хугацаа хэтрүүлж /сунгаж/ шийдвэрлэсэн, 19 өргөдөл хугацаа болоогүй /хяналтад/ байна. Нийт өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн биелэлт 94.4% ийн хэрэгжилттэй байна.

2018 оны III улирлын байдлаар хүлээн авч, шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тайланг хавсралт 1,2,3-аар тус тус гарган хүргүүлж байна.

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ

9/3525 тоот албан бичгийн
нэгдүгээр хавсралт

Эрчим хүчний яаманд 2018 оны III улирлын байдлаар иргэдээс
Төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн
өргөдөл, гомдол, санал хүсэлт

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт	Үүнээс:				
			Бичгээр	Цахим хэлбэрээр	Утсаар хандсан	Биечлэн уулзсан	Бусад
1	Эрчим хүчний яам	344	326	15	3	0	0
Тайлбар: 11-11төвөөс шилжиж ирсэн санал хүсэлтийг тайланц оруулаагүй болно. 2018 оны 10 сарын 01-ний байдлаар							

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ

a/3525...тоот албан бичгийн
хоёрдугаар хавсралт

Эрчим хүчний яаманд 2018 оны III улиралд иргэдээс Төрийн захиргааны
байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын
шийдвэрлэлтийн байдал

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Шийдвэрлэлт				Шийдвэрлэлт
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлсэн	Хугацаа хэтрүүлж /сунгаж/ шийдвэрлэсэн	Хугацаа болоогүй	
1	Эрчим хүчний яам	344	325	52	32	19	94.4%

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ

9/3525.....тоот албан бичгийн
туравдугаар хавсралт

Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн агуулга

Д/Д	Байгууллагын нэр	Зонхилж байгаа асуудал /моо, нийт өргөдөл гомдолд эзлэх хувь/
1	Эрчим хүчний яам	<p>Нийт 344 өргөдлөөс: Хүсэлт – 292 / 84.8% Гомдол – 33 / 9.5% Санал – 19 / 5.5%</p> <ul style="list-style-type: none">Түлш эрчим хүчний үйлдвэрлэлтэй холбоотой асуудлаар -146 / 42.4%Ажилд орох, гарах, чөлөө хүсэх, цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж, зэрэг төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл баталгаатай холбоотой асуудлаар – 122 / 35.4%Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа, санхүүжилт төсөв хөрөнгөтэй холбоотой асуудлаар – 56 / 16.2%Бусад асуудлаар – 20 / 5.8% <p>✓ 2018 оны III улиралд иргэд, аж ахуй нэгж байгууллагуудаас Түлш эрчим хүчний үйлдвэрлэлтэй холбоотой асуудлаар, Ажилд орох, гарах, чөлөө хүсэх, цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж, зэрэг төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл баталгаатай холбоотой мөн асуудлаар дийлэнх өргөдөл, гомдлууд ирсэн бөгөөд Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан хугацаанд холбогдох шийдвэрлэлт, арга хэмжээг авч ажилласан.</p> <p>✓ Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй “Нийслэлийн гэр хорооплын цахилгаан шугам сүлжээ, дэд станцыг өргөтгөж хүчин чадлыг нэмэгдүүлэхэд шаардагдах хөрөнгө буюу 20000 айл өрхийг 4.0кВт чадалтай цахилгаан халаагуураар халаах техникийн боломжийг бүрдүүлэх ажил” Багц ажлууд эхнээсээ гүйцэтгэж дууссантай холбогдуулан Улсын комисс ажиллаж байна. Мөн “Нийслэлд ажиллаж байгаа 68 халаалтын зуухыг буулгаж хэрэглэгчдийг төвлөрсөн дулаан хангамжид холбох” Багц ажлууд эхнээсээ гүйцэтгэж дууссантай холбогдуулан барилга байгууламжийг ашиглалтад оруулах Улсын комисс ажиллаж эхэлсэн.</p>

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ



ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН
ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛ

2018 оны 10 сарын 09 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Сайдын зөвлөлийн 2018 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн хуралдааны тэмдэглэлд:


“ХЭЛЭЛЦСЭН НЬ: V. 2018 оны III улиралд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас Эрчим хүчний сайд, Эрчим хүчний яаманд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар Төрийн захиргааны удирдлагын газрын дарга М.Баярмагнай танилцуулав.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Өргөдөл гомдлын тайлан мэдээг тогтоосон хугацаанд нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэхийг Төрийн захиргааны удирдлагын газар /М.Баярмагнай/-т даалгав.

2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас Эрчим хүчний сайд, Эрчим хүчний яаманд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлыг чиг үүргийн дагуу хүлээж авсан албан тушаалтан эцэслэн шийдвэрлэж хуулийн хугацаанд хариуг өгөх, өргөдөл, гомдлын хуулийн хугацааг хэтрүүлж шийдвэрлэх асуудлыг зогсоох, салбарын үйлдвэр компаниудад шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн өргөдөл гомдлын хариуг заавал авч, эргэх холбоотой ажиллахыг яамны бүх газар хэлтсийн дарга наарт үүрэг болгов” гэжээ.

САЙД



Ч. ДАВААСҮРЭН

008000061